

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ОНЦЛОН АНХААРАХ АСУУДЛУУД.



ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ Д.ГАНСҮХ



АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬ НЬ АНХ 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР БАТЛАГДАЖ, 2017 ОНЫ 7 ДУГААР САРЫН 1-НИЙ ӨДРӨӨС ДАГАЖ МӨРДӨГДСӨН. 4 БҮЛЭГ, 16 ЗҮЙЛТЭЙ.

1 ДҮГЭЭР БҮЛЭГТ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

2 ДУГААР БҮЛЭГТ АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭМЖЛЭГ, ХҮНДЭТГЭЛ,

ГУРАВДУГААР БҮЛЭГТ. АХМАД НАСТАНД ДЭМЖЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ, САНХҮҮЖИЛТ,

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГТ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГТЭЙ ХОЛБОГДСОН АСУУДЛУУДЫГ ЗОХИЦУУЛСАН БАЙНА.

- 
- ▶ Энэ хууль анх мөрдөгдсөн цагаас 7 жилийн хугацаанд тэр бүр нэмэлт өөрчлөлт ороогүй бөгөөд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар түүнд орсон нэмэлт өөрчлөлт нь 2025 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхлээд байна.



АХМАД НАСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН ДОТРООС
ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ, ОРОН
НУТГИЙН БАЙГУУЛАГЫН ЭРХ БАРИГЧ НАРТ
ҮҮРЭГ БОЛГОСОН БОЛОН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛАГЫН БОЛОН
АЖ АХУЙН НЭГЖ **БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ**
ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ ЗОХИЦУУЛСАН
ДООРХИ ЗААЛТУУД БАЙНА. ҮҮНД:



9 дүгээр зүйл. Ахмад
настны хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих

- ▶ **10 дугаар зүйл. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах**
- ▶ **11 дүгээр зүйл. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих**
- ▶ **11.1.Ахмад настны хөгжил, оролцоог төрөөс дараахь байдлаар дэмжинэ:**
- ▶ **11.1.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх төлөвлөгөөг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, хэрэгжүүлэх;**
- ▶ **/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./**
- ▶ **11.1.4.ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг ахмадын өдрийн хүрээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд 10 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулах.**
- ▶ **/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./**

► 12 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг

- 12.1. Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.
- 12.2. 65 болон түүнээс дээш настай ахмад настанд Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан жил бүрийн 01 дүгээр сард, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан жил бүрийн 6 дугаар сард улсын төсвөөс санхүүжүүлэн **ахмад настны наснаас хамааран** насны хишиг олгох бөгөөд насны **хишгийн хэмжээ**, олгох журмыг Засгийн газар батална.
- /Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан /

- ▶ Хуульд осон нэмэлт өөрчлөлт дотроос бидний онцлон анхаарвал зохих, ялангуяа шүүхийн захиргааны төв, орон нутгийн байгууллагад илүү хамраалтай, тэдэнд үүрэг болгосон заалтууд нь “Аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг” хуулийн дөрөвдүгээр бүлэг юм.
- ▶ Энэ бүлэгт Ахмад настны асуудлаар:
 - ▶ -Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
 - ▶ -Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
 - ▶ - Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
 - ▶ -Төрийн захиргааны төв байгууллага,
 - ▶ -Бүх шатны Засаг дарга, үүний дотор, баг, хорооны, сум дүүргийн, аймаг, нийслэлийн засаг даргын,
 - ▶ -Аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүргийг нарийвчлан зохицуулсан
- ▶ Шүүхийн захиргааны төв олон нутгийн байгууллага, түүний удирдлагууд, хамаарал бүхий ажилтнуудаас Ахмад настны тухай хуулийн “Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг” гэсэн хуулийн 4 дүгээр бүлэг, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг нарийвчлан судлах, холбогдох заалтуудыг шүүхийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан бүтээлчээр хэрэгжүүлэх нь эн тэргүүнд тавигдах шаардлага, тулгамдсан зорилт болж байна. Ингээд Ахмад насны тухай хуулийн 4 дүгээр бүлгийг бүхэлд нь авч үзье.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- ▶ 14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг
- ▶ 14.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүрэг хүлээнэ.

- 
- ▶ 14.5.Бүх шатны Засаг дарга ахмад настныг дэмжих талаар дараахь үүрэг хүлээнэ:
 - ▶ 14.5.1.баг, хорооны Засаг дарга ахмад настныг судалж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон дэмжлэг, тусламж үзүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд туслах, үнэн зөв тодорхойлолт гаргаж өгөх;
 - ▶ 14.5.2.сум, дүүргийн Засаг дарга ахмад настны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ахмад настныг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах талаар эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийг нь хамгаалах, ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь татан буугдсан, өөр орон нутгаас шилжин ирсэн ахмад настныг бүртгэж, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулах;

- 
- ▶ 14.5.3.аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаархи хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах;
 - ▶ 14.5.4.аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон сууц барих аж ахуйн нэгжийн удирдлагатай тохиролцон шинээр баригдах орон сууцны дэд бүтцэд төсвөөс оруулсан хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй орон сууцыг эзэмшилдээ авах, эхний ээлжид орон байргүй ахмад настанд хөлслүүлэх, эзэмшүүлэх, хүүхэдтэйгээ хамтран төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдүүлэх;

- ▶ 14.5.5.аймаг, нийслэлд ахмадын ордон, сум, дүүрэгт ахмадын өргөө, танхим, төв байгуулж ажиллуулах, түүнд шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт жил бүр тусгах.
 - ▶ 14.6...байгууллага нь **ажиллаж байсан ахмад настанд** нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, **соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.**
 - ▶ 14.7.Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан ...байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо **төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган** цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.
- ▶ **/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./**

- ▶ 14.8.Ахмад настны ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан, татан буугдсан бол түүний эрх, үүргийг шилжүүлэн авсан этгээд энэ хуулийн 14.6-д заасан үүргийг хэрэгжүүлнэ.
- ▶ 14.9.Аж ахуйн нэгж, байгууллага нь “Ахмадын сан”-гийн үйл ажиллагааны тайлан, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.
- ▶ /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./

▶ **15 дугаар зүйл. Ахмадын байгууллага**

- ▶ 15.1.Ахмад настны олонхийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, нийгэмд үйлчилдэг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг улсын төсвөөс, түүний салбар, нэгжийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжүүлнэ.

▶ /Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

- ▶ 15.2.Энэ хуульд заасан **ахмад настны талаархи төрийн** болон нутгийн захиргааны **байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг** ахмад настны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно.

- ▶ 15.3.Ахмад настны талаарх **төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг** болон энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг **ахмадын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг гэрээний үндсэн дээр хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.**

▶ /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./

- ▶ 15.4.Ахмадын байгууллага нь төрөөс ахмад настны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжид санал өгөх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, хяналт тавина.
- ▶ /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./
- ▶ 15.5.Ахмадын байгууллага нь ахмад настны асрамж, сувилал, үйлчилгээний байгууллагуудыг магадлан итгэмжлэх зөвлөл, хүний эрхийн иргэний зөвлөл, амьжиргаа дэмжих зөвлөл, хохирогчдын нөхцөл, аюулгүй байдлын үнэлгээ, зэрэглэл тогтоох ажлын хэсэг, зөвлөлд төлөвлөө оролцуулна.
- ▶ /Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./
- ▶ 15.6.Энэ хуулийн 15.2, 15.3-т заасан гэрээ, төсөл арга хэмжээ, гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн тайлан нь олон нийтэд нл тод, нээлттэй байна.
- ▶ /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./
- ▶

- ▶ 15.7.Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага 50 ба түүнээс дээш ахмад настантай бол ахмадуудтай харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ахмад настныг төлөөлсөн нэг хүнийг гэрээгээр ажиллуулж болно” гэж заасан.
- ▶ /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./
- ▶ Ийм учраас одоогоор 450-аас дээш ахмадтай тус Шүүхийн Ерөнхий зөвлөл болон 50 ба түүнээс дээш ахмадтай шүүхийн зарим Тамгын газрууд хуулийн энэ заалтыг үндэслэн цалин хөлсийг жил бүрийн төсөвт суулгаж, ахмадуудтай харилцах үндсэн чиг үүрэгтэй аль нэг хүнийг гэрээгээр ажиллуулж цалин хөлсийг шийдвэрлэх боломж нээгдсэн байна. Энэ заалт болон тус хуулийн 15.3-д “Ахмад настны талаарх төрийн ...байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг ...ахмадын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг гэрээний үндсэн дээр хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” гэсэн заалтыг үндэслэн Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Шүүхийн ахмадын Холбооны ажлын албаны даргыг, эсхүл аль нэг ахмад ажилтныг гэрээгээр ажиллуулж цалин хөлсийг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

- ▶ Хуулийн 1 дүгээр бүлгийн хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэг болон 2, 3, 4 дүгээр бүлгүүдэд бүхэлдээ нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.
- ▶ Хоёрдугаар бүлгийн 7 дугаар зүйлд зааснаар ахмад настанд үзүүлдэг байсан байсан 8 төрлийн үйлчилгээг нэмэгдүүлж, 12 төрөлтэй болгосон. Үүнд, **Ахмад настны:**
- ▶ 1. хувилбарт үйлчилгээ,
- ▶ 2. хөгжлийг дэмжих үйлчилгээ,
- ▶ 3. зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ,
- ▶ 4. ахмад настанд үзүүлэх сэргэн засах үйлчилгээ гэсэн үйлчилгээний шинэ төрлүүдийг баталж, үүнтэй холбоотойгоор эдгээр үйлчилгээг зохион байгуулах хэлбэрүүдийг нарийвчлан зохицуулсан нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.
- ▶ Хуулийн 7 дугаар зүйлд орсон энэхүү нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр хамгаалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/75, А 514 дугаартай хамтарсан тушаалаар **“Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх , иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгуулагаыг сонгон шалгаруулах журам”-ыг батлан гаргасан. Энэ нь:**

- ▶ -Нийтлэг үндэслэл,
- ▶ -Худалдан авах үйлчилгээ,
- ▶ - Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт,
- ▶ - Үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ауйн нэгж, төрийн бус байгуулллагад тавигдах шаардлага,
- ▶ -Бусад гэсэн гэсэн 5 бүлэгтэй.
- ▶ Түүнчлэн, Гэр бүл, хөдөлмөр хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/75, А 515 дугаартай хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам” –ЫГ
- ▶ -Нийтлэг үндэслэл,
- ▶ -Ахмад настны цогц тусламж үйлчилгээнд баримтлах зарчим,
- ▶ -Ахмад настанд цогц үнэлгээ хийх,
- ▶ -Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ,
- ▶ -Ахмад настны идвэхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ,

- 
- ▶ -Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ,
 - ▶ -Ахмад настанд үзүүлэх өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээ,
 - ▶ -Ахмад насны цогц үйлчилгээнд тавих хяналт, тайлагналт гэсэн
 - ▶ 8 бүлэгтэйгээр батлан гаргасан байна.
 - ▶ Мөн тушаалаар “Ахмад настны цогц үнэлгээний загвар” болон “Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэрэгжлийн удирдлагаар хангах журам”-ыг тус тус баталсан. Тус журам нь
 - ▶ -Нийтлэг үндэслэл, -Удирдлага, зохион байгуулалт,
 - ▶ -Байгууллагуудын чиг үүрэг,
 - ▶ -Мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа,
 - ▶ -Бусад гэсэн 5 бүлэгтэй байна.
 - ▶ Түүнчлэн ахмад настны амжиргаа, хөдөлдмөр эрхлэлт, хөгжил оролцоо, дэмжих асуудал болон эрүүл мэндийг хамгаалах тэдэнд үзүүлдэх хүндэтгэл насны хишгийн асуудлууд, дэмжлэг үйлчилгээ үзүүлэх журам , санхүүжилттай холбогдсон зохицуулалтыг нарийвчлан тодотгож өгсөн байна.

- 
- ▶ **16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**
 - ▶ 16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
 - ▶ 16.2.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
 - ▶

Монгол улсын хууль

2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

- ▶ 1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 145,4 дэх хэсэг нэмсүгэй.
- ▶ “145,4. Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтайтай аж ахуйн нэгж, байгууллга нийт ажлын байрныхаа 2-оос доошгүй орон тоонд Ахмад настны тхай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлдтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.”



“Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан төдийгүй, сангийн яамнаас 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 03/ 7689 дугаартай Мэдээллийг төрийн захиргааны төв байгуллагууд хүргүүлсний зэргэцээ Ахмадын сан байгуулж ажиллуулах Зөвлөмжийг хавсаргасан байна.

Энэ талаар хөтөлбөрийн дагуу Удирдах зөвлөлийн бусад гишүүд мэдээл өгнө.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа!